



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дөргөн сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2024/05/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэбүрэн хот 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Эрдэнэцэцэг Утас: 99019943 Цахим хаяг: erdenetsetsegd@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2024.03.22. № 1/118
танай _____-ны № _____-т

ДӨРГӨН СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН
ЗАХИРАГЧ Л.ЦЭДЭН-ИШ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дөргөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дөргөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 3 төсөвт байгууллага, 2 тусгай сан, сумын Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Соёлын төв, зэрэг байгууллагуудын тогтмол зардлыг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдсэн байна.

Дөргөн сумын 2023 оны төсвийн орлогыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 03 дугаар тогтоолоор татвар, татварын бус орлогыг 369241.9 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 458084.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж орлогыг 88842.6 мянган төгрөгөөр буюу 27.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлын үр дүнд сумын хөрөнгө 516.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын ИТХ-ын 03 тоот тогтоолоор "сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2023 оны хэрэгжилтийг 86.5 хувь буюу "хангалттай" гэж дүгнэжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшний боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	647,171.6	790,439.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	213,621.0	449,967.9
33	АВЛАГА	266,251.2	197,141.6
34	УРЬДЧИЛГАА	117,689.3	104,189.3
35	БАРАА МАТЕРИАЛ	49,610.1	39,140.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,377,401.9	2,652,688.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,377,401.9	2,652,688.4
39200	Биет хөрөнгө	2,342,923.7	2,618,492.2
39300	Биет бус хөрөнгө	34,478.2	34,196.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,024,573.4	3,443,127.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	25,250.2	17,430.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	25,250.2	17,430.9
41300	Өглөг	25,250.2	17,430.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,999,323.2	3,425,696.5
51	Засгийн газрын хувь оролцоо	2,999,323.2	3,425,696.5
51100	Засгийн газрын оруулсан капитал	795,806.1	795,806.1
51200	Хуримтлагдсан үр дүн	2,021,348.0	2,447,721.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	182,169.0	182,169.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,024,573.4	3,443,127.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,718,442.40	2,181,440.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	308,754.60	450,969.10
110	Орлогын албан татвар	265,258.10	383,016.70
1100	Хувь хүний орлогын албан татвар	265,258.10	400,986.30
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(17,969.60)
113	Хөрөнгийн албан татвар	29,364.80	46,822.90
118	Бусад татвар, төлбөр, хураамж	14,131.70	21,129.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,560,270.60	543,304.70
120	Нийтлэг татварын бус орлого	1,560,270.60	543,304.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	849,417.20	1,187,166.60
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,405,709.30	1,755,067.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,405,709.30	1,755,067.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,331,180.20	1,754,007.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	326,771.00	409,377.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,630.80	50,474.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	367,229.00	33,578.70
2104	Хангамж, бараа материалын зардал	168,098.70	521,875.20
2105	Норматив зардал	128.30	281.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,201.80	7,506.60
2107	Томилот, зочны зардал	2,904.60	4,772.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,712.20	413,898.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	405,503.80	312,243.80

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,529.10	1,060.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,312,733.10	426,373.30
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,589,102.00	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(3,276,368.90)	426,373.30

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан(төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,103,140	1,549,283	2,781,908	6,434,330
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,307,334)	(1,367,114)	2,515,809	(158,638)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	795,806	182,169	5,297,717	6,275,692
4	Тайлант үеийн үр дүн		-	(3,276,369)	(3,276,369)
5	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	795,806	182,169	2,021,348	2,999,323
6	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	795,806	182,169	2,021,348	2,999,323
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	795,806	182,169	2,021,348	2,999,323
8	Тайлант үеийн үр дүн		-	426,373	426,373
9	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	795,806	182,169	2,447,721	3,425,697

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,228,551.5	1,743,886.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	308,754.6	450,969.1
110	Орлогын албан татвар	265,258.1	383,016.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	265,258.1	400,986.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-17,969.6
113	Хөрөнгийн албан татвар	29,364.8	46,822.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	14,131.7	21,129.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,487.5	2,352.3
1181	Газрын төлбөр	5,806.2	18,667.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,838.0	109.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	61,368.5	65,961.2
120	Нийтлэг татварын бус орлого	61,368.5	65,961.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	858,428.4	1,226,956.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	978,618.1	1,066,276.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	978,618.1	1,066,276.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	872,435.6	1,065,066.9

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	326,747.8	408,575.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,624.3	48,954.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	367,229.0	33,755.2
2104	Хангамж, бараа материалын зардал	26,929.7	35,291.7
2105	Норматив зардал	128.3	419.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,201.8	8,826.6
2107	Томилолт, зочны зардал	2,904.6	4,772.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,772.2	416,431.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,897.9	108,040.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	106,182.5	1,210.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	249,933.4	677,609.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	172,216.4	441,162.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	172,216.4	441,162.5
2200	Дотоод эх үүсвэрээр	172,216.4	441,162.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-172,216.4	-441,162.5
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-1,100.0	-100.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,100.0	100.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	76,617.0	236,346.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	137,004.0	213,621.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	213,621.0	449,967.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,673,625.1	1,484,026.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,090,726.1	1,042,763.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,088,884.6	1,041,553.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	471,993.2	408,575.8
210101	Үндсэн цалин	264,639.8	263,775.2
210102	Нэмэгдэл	151,928.7	98,943.3
210104	Урамшуулал	10,042.0	720.0
210105	Гэрээт ажлын хөлс	45,382.7	45,137.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,999.3	48,954.8
210201	Тэтгэврийн даатгал	40,119.5	33,624.7
210202	Тэтгэмжийн даатгал	4,719.9	3,954.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,776.0	3,215.3
210204	Ажилгүйдлийн даатгал	944.0	726.4
210205	Эрүүл мэндийн даатгал	9,439.9	7,433.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	441,017.9	432,968.7
210301	Гэрэл, цахилгаан	28,036.5	24,462.9

210302	Түлш, халаалт	407,341.4	405,116.1
210303	Цэвэр, бохир ус	5,640.0	3,389.7
2104	Хангамж, бараа материалын зардал	30,497.7	28,478.3
210401	Бичиг хэрэг	5,190.7	4,551.5
210402	Тээвэр, шатахуун	21,896.0	21,304.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,411.0	2,622.3
2105	Норматив зардал	502.7	419.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	502.7	419.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,430.2	11,826.7
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	280.6	277.0
210604	Урсгал засвар	13,149.6	11,549.7
2107	Томилолт, зочны зардал	6,625.1	4,772.0
210702	Дотоод албан томилолт	6,625.1	4,772.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,724.2	13,502.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,074.3	11,263.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	369.4	-
210803	Даатгалын үйлчилгээ	145.0	145.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	210.0	196.2
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30.0	22.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,772.5	1,752.3
210807	Газрын төлбөр	123.0	123.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,094.3	92,055.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,865.1	91,411.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,229.2	644.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,841.5	1,210.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,841.5	1,210.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,841.5	1,210.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	532,899.0	441,162.5
2200	Дотоод эх үүсвэрээр	532,899.0	441,162.5
220001	Барилга байгууламж	430,056.7	363,574.1
221001	Их засвар	35,000.0	34,956.4
222001	Тоног төхөөрөмж	16,000.0	16,000.0
223001	Бусад хөрөнгө	51,842.3	26,632.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	50,000.0	100.0
230001	Эргэж төлөгдөх зээл	50,000.0	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,673,625.1	1,484,026.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	428,405.1	428,405.1
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	428,405.1	428,405.1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,136,121.1	996,170.3
132001	Орон нутгийн төсвөөс	1,136,121.1	996,170.3
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	109,098.9	59,450.8
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605.0	605.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000.0	58,845.8
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	58,493.9	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
610001	Төсвийн байгууллага	2	2

62	АЖИЛЛАГСДЫН ТОО	28	28
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	5	5
620004	Гэрээт ажилтан	6	6
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28	28
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	8
650010	Гэрээт ажилтан	3	3
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	I НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	41,311.9	90,740.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,143.3	88,701.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,143.3	88,701.6
2104	Хангамж, бараа материалын зардал	-	6,813.4
210402	Тээвэр, шатахуун	-	6,813.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	715.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	715.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,143.3	81,172.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,846.3	81,172.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	297.0	
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,168.6	2,038.8
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	21,168.6	
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		2,038.8
	II ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	41,311.9	90,740.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,311.9	90,740.5
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,732.6	25,180.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,243.4	39,789.5
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,335.9	25,771.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 13625.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 13625.9 мянган төгрөгийн алдааг залруулан бүртгэсэн. Үүнд:

- ✓ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтаас барьцаа хөрөнгө суутгаж авсан 13625.9 мянган төгрөгийг өглөгөөр бүртгээгүй,

Аудитаар нийт 249376.9 мянган төгрөгийн алдаа² илэрснээс 64683.1 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, татварын орлого нэмэгдүүлэх, зээлийн эргэн төлөлтийг шийдвэрлэх 148488.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 36205.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын төсөвт байгууллагуудын хэрэглээний усны шугам, сүлжээ худаг гаргах ажлын техник хяналтын зардал, магадалшгүй ажлын төсвийг суутгаж аваагүй 5890.0 мянган төгрөг,

Илрүүлэлт: Сумын төвийн гэрэлтүүлгийн ажлаас ТХЗ суутгаагүй, Магадалшгүй ажлын хүлээлгэж өгсөн акт байхгүй, төсөвт өртгийг суутгаж аваагүй 2743.1 мянган төгрөг,

Илрүүлэлт: Малжуулах зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдээгүй, тооцоо нийлж авлага баталгаажуулаагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй, төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдсан 56050.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 11-р зүйлийн 11.1-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналт, бүртгэл, хяналт болон эцсийн үр дүнг тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна", Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2012 оны 181 тоот тушаалын 1-р хавсралт Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм БНБД 81-94-12 4.11 дэх заалт", Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдээгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Төлбөрийн акт тогтоох

3.2 Албан шаардлага

3.2.1 Хоршоо хөгжүүлэх сангийн зээлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ХХС-ийн насжилт өндөртэй авлага шийдвэрлээгүй, авлагын үр дүн буурсан, зээлийн үлдээгдлийн тооцоо нийлж баталгаажуулаагүй, зээл авсан иргэд зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлийн эргэлт удааширч байхад эргэн төлүүлэх арга хэмжээ аваагүй, дараагийн зээл авах иргэдийн боломж алдагдсан 148488.7 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалт, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдээдлийг хангахгүй байна

Шийдвэрлэлт: Албан шаардлага өгөх

3.2.2 Татварын орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутагт ажиллаж байгаа байцаагч нарын ажлын хариуцлага сул, төлөвлөсөн татварын ногдуулалт, орлогын төлөвлөгөө бүрэн биелээгүй, татвар ногдуулалт хийсэн ажлын баримт тайлан тооцоо хийсэн баримтууд байхгүй, малын хөлийн татварыг өмнөх оны татварын суурь судалгаанд үндэслэж орлогыг бодитой төлөвлөөгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэн заалт, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдээдлийг хангахгүй байна

Шийдвэрлэлт: Албан шаардлага өгөх

3.3 Зөвлөмж

3.3.1 Хөрөнгө оруулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Адапт төслөөр хэрэгжсэн Агваш багт Булгийн эхийг хашиж хамгаалах ажил, Гамшгийн үеийн нөөц бүрдүүлэх агуулахын оролцооны ТХЗ, МА-ын зардал, барьцаа хөрөнгө суутган тооцоо хийсэн, хяналт хэрэгжүүлсэн баримтгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 11-р зүйлийн 11.1-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналт, бүртгэл, хяналт болон эцсийн үр дүнг тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна" гэсэн заалттай нийцэхгүй байна

Өгсөн зөвлөмж: Адапт төсөлтэй хамтран хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн дараах хяналт хэрэгжүүлэх

3.3.2 Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сангийн хөрөнгийг иргэдийн санал аваагүй, нийтийн эрх ашигт нийцээгүй хөрөнгийн шинж чанар агуулаагүй урсгал зардалд зарцуулсан, сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн хөрөнгийн бүртгэл, ашиглалтад тавих дотоод хяналт сул, анхан шатны баримт бүрдүүлэлт хангалтгүй, зарим ажлын баталгаат хугацааны барьцаа хөрөнгө суутгаагүй, ЗДТГ болон ОНХС-аас санхүүжиж байгаа өвсний тооцоо хийж үлдээдлийг баталгаажуулаагүй, авлага өглөгийн тооцоо хийгээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.3.3-д "үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ой арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардалд", 60.3.4-д нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа", 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтаар баталгаажихгүй ажил гүйлгээг гаргахгүй байх, өвсний тооцоо хийж авлага өглөгийг баталгаажуулах

ХОА-2024/05/НА-СТА-ТТЗ

3.3.3 Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал

Илрүүлэлт: Авто тээврийн хэрэгсэлд бусад тээврийн хэрэгслээс ялгагдах өнгө бүхий дугаар хэрэглээгүй, сангийн хөрөнгөөс шагнал, урамшил, бусад зардалд хөрөнгө зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь ТХТХ-ийн 14-р зүйлийн 14.4-д "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ", 15-р зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах

3.3.4 Хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Цэвэр усны шугам сүлжээ байгуулах ажлын хүрээнд гаргасан худгийн усны нөөц, ундны усны эрүүл ахуйн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт гараагүй, аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа асуудалд шийдвэр гаргаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худгийн усны эрүүл ахуйн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт гаргаж, ус ашиглагч байгууллагад хяналт хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ ү

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Дөргөн ТТЗ	ОНХС-ийн авлага, өглөг зөрүүтэй илэрхийлэгдсэн	1	13.625.9			1	13.625.9	1	13.625.9				
Нийт дүн		1	13.625.9			1	13.625.9	1	13.625.9				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
						Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10
Дөргөн ТТЗ	Сумын төсөвт байгууллагуудын хэрэглээний усны шугам, сүлжээ худаг гаргах ажлын ТХЗ,МА-ын төсвийг суутгаж аваагүй	1	5.890.0	1	5.890.0				
	Сумын төвийн гэрэлтүүлгийн ажлаас ТХЗ суутгаагүй, Магадалшгүй ажлын хүлээлгэж өгсөн акт байхгүй, төсөвт өртгийг суутгаж аваагүй	1	2.743.1	1	2.743.1				
	Малжуулах зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй,	1	56.050.0	1	56.050.0				
	ХХС-ийн насжилт өндөртэй авлага шийдвэрлээгүй, авлагын үр дүн буурсан, зээлийн үлдэгдлийн тооцоо нийлж баталгаажуулаагүй, зээл авсан иргэд зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлийн эргэлт удааширч дараагийн зээл авах иргэдийн боломж алдагдсан	1	148.488.7			1	148.488.7		
	Орон нутагт ажиллаж байгаа байцаагч нарын ажлын хариуцлага сул, төлөвлөсөн татварын ногдуулалт, орлогын төлөвлөгөө бүрэн биелээгүй, татвар ногдуулалт хийсэн ажлын баримт тайлан тооцоо хийсэн баримтууд байхгүй, малын хөлийн татварыг өмнөх оны татварын суурь судалгаанд үндэслэж орлогыг бодитой төлөвлөөгүй	1					1		
	Адапт төслөөр хэрэгжсэн Агваш багт Булгийн эхийг хашиж хамгаалах ажил, Гамшгийн үеийн нөөц бүрдүүлэх агуулахын оролцооны ТХЗ, МА-ын зардал, барьцаа хөрөнгө суутган тооцоо хийсэн, хяналт хэрэгжүүлсэн баримтгүй,	1							1

Сангийн хөрөнгийг иргэдийн санал аваагүй, нийтийн эрх ашигт нийцээгүй хөрөнгийн шинж чанар агуулаагүй урсгал зардалд зарцуулсан, сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн хөрөнгийн бүртгэл, ашиглалтад тавих дотоод хяналт сул, анхан шатны баримт бүрдүүлэлт хангалтгүй, зарим ажлын баталгаат хугацааны барьцаа хөрөнгө суутгаагүй, ЗДТГ болон ОНХС-аас санхүүжиж байгаа өвсний тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, авлага өглөгийн тооцоо хийгээгүй	1						1	36.205.0
Цэвэр усны шугам сүлжээ байгуулах ажлын хүрээнд гаргасан худгийн усны нөөц, ундны усны эрүүл ахуйн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт гараагүй, аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа асуудалд шийдвэр гаргаагүй	1						1	
Нийт дүн	8	213.171.8	3	64.683.1	2	148.488.7	3	36.205.0

4.3 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мян төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс	
			Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авто тээврийн хэрэгсэлд бусад тээврийн хэрэгслээс ялгагдах өнгө бүхий дугаар хэрэглээгүй, сангийн хөрөнгөөс шагнал, урамшил, бусад зардалд хөрөнгө зарцуулсан	1	-	1	-
Дүн	1	-	1	-

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1			1			
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			